# まんがでわかる
# ビルクリーニング業の安全衛生

Монгол хэл
モンゴル語版

**Комикоор танилцах**
**Барилга цэвэрлэгээний аюулгүй байдал, эрүүл ахуй**









**Хөдөлмөрийн ослын тоо**

| | | |
|---|---|---|
| 1 | Явганаас бэртэх | 1705 хүн |
| 2 | Нурж унах, Өндрөөс унах | 656 хүн |
| 3 | Хөдөлгөөний инерци, эвгүй хөдөлгөөнөөс үүдэлтэй | 370 хүн |
| 4 | Хавчигдсан, татагдсан | 203 хүн |
| 5 | Мөргөлдсөн | 200 хүн |

Лавлах материал: Хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх төв хороо
"Хөдөлмөрийн ослын шинжилгээний мэдээлэл, барилга засвар үйлчилгээний ажил
(2019оны 8 сар)


Тийм байна шүү.
"Явганаас бэртэх" гэж болов янз бүрийн ослын жишээ байдаг.
Жишээ нь: Хоёр гартаа дүүрэн юмтай, хөл нь утсанд тээглэж унасан,
Цэвэрлэгээний үеэр нойтон шалан дээр хальтарсан гэх мэт тохиолдлууд байдаг.
Бидний өдөр тутамд ч бас их тохиолддог шүү.
Хөдөлмөрийн осол бол бидний хамар дор л үүсэж байдаг гэсэн үг шүү дээ.


Яавал урьдчилан сэргийлж чадах болоо?
Эргэн тойрноо эмх цэгцтэй байлгаж хальтарч унахааргүй орчинг бүрдүүлэх нь чухал.
Эмх(Seiri )
Цэгц(Seiton)
Цэвэрлэгээ(Seiso)
Цэвэр(Seiketsu )
↓
4S
Эмхлэх, цэгцлэх чинь төвөгтэй шүү дээ.
хахаха
Гол нь анхааралтай байвал болчихно биздээ?
Айн?
Зөвхөн өөрийн төдийгүй хэн хүнд аюулгүй хөдөлмөрийн орчин бүрдүүлэх нь хамгийн чухал!
За!


Ажлын талбарт цэвэрлэгээний төхөөрөмж болон ариутгалын бодис ашигладаг. Түүний хэрэглээг нь андуурах юм бол хүнд гэмтэл учруулж ч болзошгүй юм.
Remover
清掃中
Зөвхөн өөртөө гэлгүй, барилгын үйлчлүүлэгчдэд ч гэмтэл учруулахгүй байхыг анхаарах хэрэгтэй.
Хүнд бэртлийн улмаас ажиллах боломжгүй болвол гэр бүлийнхэн нь ч санаа зовно, цалин орлогын тал дээр ч бас хэцүүдэх байх даа.
Мхм. Тиймээс ч урдчилан арга хэмжээ авах нь чухал!
Цагийг нь тулгалгүй ажил үүргээ гүйцэтгэх, ажлын багаж хэрэгслийг тогтсон зааврын дагуу зөв хэрэглэх.
Ажлын үед хамгаалалтын хэрэгсэл ашиглах дүрмийг баримтлах


"Явганаас бэртэх" ямар хөдөлмөрийн ослын жишээ байдаг вэ?
Жишээ нь, 2 гартаа ууттай хог барьж явж байгаад, шатнаас хальтарч унасан.
Цонхын шил арчиж байхдаа тэнцвэр алдаж, эвхдэг шатнаас унасан ослууд байдаг.
Аюултай юм аа…!
カチッ…
Заа
ガーッ
おおっ
Бодит ажлын талбайг
1
авч үзэцгээе
ジジ…

# Жишээ 1


Нэгэн оффисын барилга
Өнөөдөр ээлжит цэвэрлэгээний өдөр.
Өнгөлөгчөөр хуучин ваксыг арилгаарай.
За!
Өнөө орой хайртай хамтлагийн минь амьд тоглолттой.
Хурдхан ажлаа дуусгая.
Хуулагч бодис бэлдчихсэн, дэвсгэр тохируулаад…
хурдлахгүй бол
Ийм байхад болох биз.


REMOVER
За эхлэе.
Зогсчихов уу даа?
Тохиргоог нь буруу хийчихэв үү?
Амьд тоглолт эхлэх нь ээ…
Ядаргаа ядаргаа, бээлийгүй хийчихье
Цаг алга!


Зүгээр дээ.
Жоохон хүрсэн ч, дараа нь угаачихвал…
За, тохиргоо дууслаа.
Ямар ч байсан эртхэн дуусгачихаад,
Хурдхан амьд тоглолт руу гаа явъя.
Юу вэ…?
Шал хатаагүй л байна.
Ааа!?


Ёоо ёо
Яасан бэ?
Бөөн чимээ сонсогдох чинь
…бүдрээ юу?
Зүгээр ээ…


Яанаа...
ビタアン
Ахлах аа
Ёоо ёо
Уучлаарай, шал хатаагүй байна... Та зүгээр үү?
Зүгээр ээ, баярлалаа
Бээлий өмсөөгүй юм уу даа?!
Нүцгэн гараараа хуулагч бодисонд хүрсэн үү?
Тийм ээ, яараад...


REMOVER
Хуулагч бодисонд нүцгэн гараараа хүрвэл
Хурц түүралт гарах тохиолдол ч байдаг юм шүү дээ.
Өнөөдөр бүр анхан шатнаас нь эхлээд заахаас даа!
Үгүй шүү. Одоо л сурч өсөх боломж!
Үгүй ээ, би өөр ажилтай...
Эцэст нь, цэвэрлэгээний үндсэн ойлголтыг дахин заалгасаар амьд тоглолтондоо амжсангүй.
Сайн байлаа.
良かったわー
サイコー
Янзтай
"Яарч байх тусам болгоомжтой"
Яарвал сайн зүйл болохгүй гэдгийг ойлгосон

# Жишээ 2


Нэгэн худалдааны газрын ариун цэврийн өрөө
За, эхлэх үү?
Өнцөг булан бүрийг цэвэрхэн болгоцгооё.
30 минутын дараа
За ингээд шал цэвэрлэж дууслаа.
Таславч болгоны суултуурын эргэн тойрон хэцүү юм аа.
Сайн цэвэрлэхгүй бол бохирдол үлдчихдэг.


Юу вэ?
Ийм газар бөөн тоос.
Арчихгүй бол.
Арчигч
Үнэндээ бол зориулалтын "арчигч" ашигладаг л даа.
Авчирах гэж төвөг төвөг.
Ерөөсөө суултуур дээр зогсож байгаад цэвэрлэчихье.


Хөөх
Цэвэрхэн болсон болов уу?
Ммм, арай л болоогүй санагдаад байна даа
Нэг хоёр...
Ингээд
Дахиад жоохон
Ээ, бурхаан


Яанаа...
Ёоо ёо ёо, ёстой баларсан юм.
Гэхдээ, тэнд ч бас бохир байна.
Ингэж байгаад цэвэрлэчихье.



Яанаа...
Юу вэ? Хүн байна уу даа?
Нээрээ, тийм!
"Цэвэрлэгээ хийж байна" гэсэн самбараа гаргаж тавихаа мартчихаж.
清掃中
足元にご注意!
Та, зүгээр үү?!
Ямар ч байсан үйлчлүүлэгчид туслахгүй бол!
Ёоо, ёо ёо




Хөөх, юу болоо вэ?
Юуны түрүүнд суултуур дээр зогсож цэвэрлэгээ хийж болохгүй.
Дүрмээ баримтлаарай.
Дараа нь "Цэвэрлэгээ хийж байна" гэсэн самбарыг заавал эхлэхийн өмнө тавина.
あ、清掃中だ
清掃中
足元にご注意!
Ингэснээр үйлчлүүлэгчид ч бас анхааралтай явцгаах болно.
こっちこそすいません
Намайг ч бас уучлаарай.
Энэ удаад гайгүй өнгөрлөө, хэрэв бэртэл авсан бол бөөн юм болно шүү.
"Дүрэм журманд заавал утга байдаг"
Үүнээс хойш тэр дүрэм журмыг төвөгшөөлгүй баримталдаг болсон.

# Жишээ 3


Өнөөдөр хамтдаа сайн ажиллацгаая!
Нэгэн зочид буудлын өрөө
Тусалж дэмжээрэй.
Би ахмад ажилчин учраас юу ч байсан асуугаарай.
Эхлээд хог түүхээс эхлэе.
Өчигдөр хөл бөмбөг үзсэн үү? Сайн байсан шүү.
Янзтай тоглолт байсан. Дэлхийн аваргын тэмцээнийг тэсэн ядан хүлээж байна шүү.
4 жилд 1 удаа болохоор удаан хүлээх юм аа.
Ёоо, ёо ёо


Ямар нэгэн юм хатгачихлаа. Зүү юм болов уу
Зүгээр үү?
Аан, зүгээр ээ
Өрөөн доторхыг түүнд даатгаад, би өрөө угаалгын өрөөг. Ямар их чийг вэ…
Таазан дээрх усыг арчихгүй бол, мөөгөнцөрдчихнө.
Өө, тааз цэвэрлэдэг шүүрээ мартчихаж.
Өөр арга алга, банны ирмэг дээр зогсож байгаад арчъя.
Иймэрхүү байхад яах ч үгүй биз.


За, ингээд сайхан арччихлаа.
Яанаа...
Аюултай байлаа даа...
Унасан бол том осол болох байлаа шүү.
Угаалгын өрөөний цэвэрлэгээ дууслаа.
Сайн ажиллаа.
!?


Зүгээр үү?
Айн?
Хувцсанд чинь цус наалдчихсан байна.
Айн, энэ юу вэ?
Гялс ороо янзлаж дуусгачихаад
Эмнэлэг явцгаая аа.
Хог хаях үед ямар нэгэн юманд хатгасан байж магадгүй
Анзаармагц, улам өвдөж байна.


Аааа
しっかりいいいい
Тэсээрэй
Хөлийнхөө чигчий хуруугг аймаар цохичихлоо
おおぉ
Яасан бэ?
Хүн гэмтчихлээ...!
何があった!?
Юу болсон бэ?
大丈夫ですか!?
Зүгээр үү?
おおぉ
Хурууны гэмтэл зүгээр дээ.
総合病院
Тариурын зүү шиг зүйл хатгасан ул мөр байгаа учраас,
юутай ч, цусны шинжилгээ авья.
画鋲
Бичгийн хадаас
インスリン注射器
инсулин, тариур
ガラスの破片
Шилний хагархай
Ямар ч үед хогтой нүцгэн гараараа харьцаж огт болохгүй. Юу хаясан байгааг мэдэхгүй шүү дээ.
түүнээс өөр тариур ч гэсэн байх боломжтой..!
でっ…
Дээр нь хувийн яриа ихэдвэл
Анхаарал сарнина шүү дээ.
Бас, өндөр газарт дүрмийн дагуу шүүр ашиглаарай.
За...
"Ажилдаа дассан үе хамгийн аюултай"
Тэр ой тойндоо сайн тогтоож авлаа.
しゅん…






# Барилга цэвэрлэгээний ажилд анхаарах зүйлс

## 1 Өндөр газарт ажиллах



Өндөр газарт бохирдол байгаа бол тэнцвэр тогтворгүй юм руу авиралгүй, дүрмийн дагуу тогтоогдсон арга барилаар цэвэрлэнэ.

## 2 "Цэвэрлэгээтэй" гэсэн самбар байрлуулах




Цэвэрлэгээний үеэр иргэдийг орж ирэхээс сэргийлж, "Цэвэрлэгээтэй" гэсэн бичиг бүхий самбар байрлуулна.

## 3 Давчуу газарт ажиллах




00-ийн өрөөний булан зэрэг давчуу, жижиг газрыг цэвэрлэхдээ толгойгоо цохиж гэмтэхээс сэргийлж, анхааралтай байгаарай.

## 4 Бээлий өмсөх



Вакс хуулагч бодис гарт хүрвэл арьс үрэвсүүлдэг тул, заавал бээлий өмсөж заншаарай.




Зургаар суръя

Ажил дунд нуугдаж буй аюулыг мэдэж авцгаая.

# Аюулаас урьдчилан сэргийлэх сургалт (KYT)

## Q Хаана аюултайг бодоцгооё




## A Гол анхаарах зүйл энэ!




1 Угаалтуур дээр авирч болохгүй.



2 Цэвэрлэгээний хэрэгслийг газар орхихгүй байх.



3 “Цэвэрлэгээ хийж байна” гэсэн самбарыг орох хаалган дээр тавих




**Өөр ямар аюулын тэмдэг байгааг бодож үзэцгээ.**

厚生労働省
Ministry of Health, Labour and Welfare

Комикоор танилцах

# Барилга цэвэрлэгээний аюулгүй байдал, эрүүл ахуй

2020 оны 3 сарын хэвлэл

Эрхлэн гаргасан: Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Төлөвлөсөн: Mizuho Information & Research Institute, Inc.
Хянан тохиолдуулсан: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын материал бэлтгэх комисс
Барилгын цэвэрлэгээнд хамаарах аюулгүй ажиллагааны сургалтын материал бэлтгэх ажил
Боловсруулсан: Sideranch Inc.

Тус материалын талаарх лавлагаа

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн стандартын хороо, Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар, Аюулгүй байдлын хэлтэс